

МОНГОЛ ШҮЛЭГ ДЭХ ХОЁР БА ДӨРВӨН МӨРТ ШҮЛГИЙН БҮТЭЦ ТОГТОЛЦОО

Г.Галбаяр

Түлхүүр үг: *Шүлэг, монгол шүлэг, бадаг, бүтэц, хоёр мөр, дөрвөн мөр*

УДИРТГАЛ

Шүлэг тодорхой утга илэрхийлж, айзам хэмнэлд захирагдах зэрэгцээ өгүүлбэрүүд буюу мөр /шад/-үүдээс бүрддэг зүйл. Шүлгийн онолын ойлголтоор бол нэг бадаг шүлгийг бие даасан шүлэг гэж томъёолдог байна. Энэ нь бадаг шүлэгт аливаа шүлэгт байх бүх шинж хадгалагддагийг илэрхийлж байгаа хэрэг. Нэг бадаг нь шүлгийн үндсэн нэгж болохын хувьд туурвигч үндэстнийхээ сэтгэлгээний онцлогийг ямар нэг байдлаар илэрхийлдэг онцлогтой байна.

Монгол хэлний үг зүйг судалсан зарим эрдэмтэд бадаг гэдэг үгийг самгарид хэлний “падака” гэсэн үгээс гаралтай гэж үзсэн байна. Энэ “падака” гэдэг үгийн “ка” нь ямар нэг зүйлийн хэмжээг багасгах утга заадаг дагавар тул үгийн үндэс нь “пада” юм. А.А.Макдонеллийн “Самгарди-англи хэлний толь”-д “пада” (ск. *ᠯᠠᠳᠠ* pad-ä) гэдэг үг нь *хүн амьтны хөл, аливаа зүйлийн тулгуур багана, тэрэгний дугуй болоод усны ёроол, мод ургамлын үндэс зэргийг илтгэнэ* (1893:152) гэх зэргээр нэлээд дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна. Энэ нь уг үгийн олон салаа утгыг нарийвчлан заасан хэрэг юм. Өгүүлэн буй салаа утгуудаас үзвэл ихэнх нь ямар нэг зүйлийн тулгуур, улмаар тэрхүү тулгуур нь үндсэн зүйлээ тулж хөдөлгөх шинжийг заасан болох нь тодорхой харагдаж байна. А.А.Макдонелл уг толь бичигтээ “Пада” гэдэг үгийн олон салаа утгыг гаргахдаа шүлгийн тухайд ч дөрөвний нэг хувь болохыг цохон тэмдэглэсэн байна. Энэ саналд үндэслэн монгол шүлгийн онол түүхийг судалсан судлаач Д.Цэрэнсодном “*Эрт цагийн хүмүүс шүлэг дуу аялах, зохиохдоо хүн малын хөл гарын хөдөлгөөн, алхаа гишгээнд тохируулан дөрвөн мөчийн хөдөлгөөн гишгэцийг нэг шүлэг хэмээн тооцож байсан*” (1977:10) гэж үзжээ. А.А.Макдонеллийн бичсэнд тулгуурлан авч үзвэл эртний Самгарид, Энэтхэг зэрэг дорно дахинд бадаг бол тухайн шүлгийн үндсэн тулгуур суурь, бадаг голчлон шүлгийн дөрөвний нэг хэмжээтэй байна гэж ойлгогдож байгаа бол Д.Цэрэнсодном шүлгийн үндэс суурь нь бадаг, монгол шүлэгт бадаг дөрвөн мөртэй байна гэж үзсэн байна. Нэгэн үе монголчууд бадаг хэмээх нэр томъёог шүлгийн мөр лүгээ адил дүйлгэн ойлгож байсан байна. Тодруулбал, зохиолч В.Инжаннаши “Нэгэн давхар асар” бүтээлдээ “*Таван үгийн найман бадаг*” (1957:50) гэж бичсэн нь тав таван үгээс бүрдэх найман бадаг шүлгийн тухай өгүүлсэн болох нь тодорхой байна. Мөн С.Шагжийн “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”-т бадаг гэдэг үгийг тайлбарлахдаа “*нэгэн шүлгийн дөрвөн хувийн нэг мэтийн*” (1937:242) гэжээ.

Өрнө дахинд шүлгийн бадаг хэмээх үг нь эртний грек хэлний *эргэх, эргэлдэх, эхэнд байсан зүйл дахин давтагдаж эргэлдэх гэсэн утга* (Kathleen Morner, Ralph Rausch, 1998:242) бүхий строфе (strophe) (гр. *στροφή*) гэсэн үгнээс үүсэлтэй гэж үздэг байна. Энэ үгийн утга нь

бадаг бол шүлгийг бүрдүүлэх үндсэн тулгуур нь, тухайн тулгуур хэсэг тодорхой давтамжтай дахин дахин давтагдаж шүлгийг бүтээнэ гэжээ. С.Буяннэмэх “Уран зохиолын үүд” хэмээх онолын бүтээлдээ “бадаг бол хэдэн ч шад байж болно, харин тэр бадаг заавал нэг утга илэрхийлсэн байна. Түүгээр ч барахгүй тэр бадагт тэрхүү утгыг шингээсэн гол шад гэж байдаг” (1935:34) гэж өгүүлжээ. Үүнээс үзвэл бадаг нь шүлгийн хэм хэмнэл, хөг аялгуу, утга зэргийг агуулсан хамгийн бага нэгж ажээ. Өөрөөр хэлбэл, “бадаг бол шүлэг холболтын нарийн ёс горимын дагуу эмхэрч удаах мөрийн байгуулалтанд журмаа хэвээр хадгалдаг хэд хэдэн мөрийн цогц байгууламж юм.” (Цэдэв Д. 1974:107)

Дээрх өгүүлсэн зүйлсийг багцлаж үзвэл шүлгийн мөрүүд тодорхой холбоц, хэм хэмнэлээр холбогдон нэгдэж, нэгдмэл нэг утга бүхий бүтэц үүсгэснийг шүлгийн бадаг хэмээн нэрлэдэг байна. Шүлгийн үндсэн суурь нэгж нь бадаг тул шүлэгт эхний бадгийн бүтэц тодорхой давтамжтайгаар дахин давтагдаж шүлгийг бүтээдэг ажээ. Бадаг ерөнхий зүй тогтлоороо дахин давтагдах хэлбэрээр шүлгийг бүтээх нь өнгөн талдаа тухайн шүлгийг эмх цэгцтэй, тодорхой бүтэцтэй болгоно. Цаад утгаараа туурвигч үндэстнийхээ соёл сэтгэлгээ, зан заншлын илэрхийлэл болдог билээ. Тийм учраас монгол шүлгийн бадгийн зүй тогтол, онцлог шинжийг судлах нь монгол шүлэг судлалд чухал асуудал юм.

Монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж нь хоёр ба гурван мөрт шүлэг ажээ. Монгол хүний сэтгэлгээ, аж амьдрал, уран сайхны дүрслэлийн үүднээс хоёр нь дөрөв, гурав нь зургааг үүсгэнэ. “Монгол ардын аман зохиол (зүйр цэцэн үг, ардын дуу), бичгийн яруу найраг (“Монголын нууц товчоо”, Д.Равжаа, В.Инжаннаши, В.Гүлранс)-ийн шүлгийн жишээнээс үзэхэд хоёроос найман мөрөөр төлөв бадаг бүтээж байна. . . . Ялангуяа хоёр, дөрвөн мөрөөр бадагласан нь уламжлалт яруу найрагт зонхилж байгаа болно” (Цэдэв Д. 1974:107) Иймд монгол шүлэгт хоёр ба дөрвөн мөрөөр буюу тэгш тоот мөрөөр эсвэл гурав ба зургаан мөрөөр буюу сондгой тоотой мөрөөр ихэвчлэн бадаг үүсгэдэг байна. Мөн тусгайлан бадаг үүсгэхгүй дотоод холбоцод нь захируулан чөлөөтэй шүлэглэсэн цагаан буюу задгай шүлгийн ёс ч байна. Энэ удаад монгол шүлэг дэх хоёр ба дөрвөн мөрт шүлгийн бадгийн онцлогийн тухай авч үзэж байгаа болно.

I. МОНГОЛ ШҮЛЭГ ДЭХ ХОЁР МӨРТ ШҮЛГИЙН БҮТЭЦ ТОГТОЛЦОО

Хүн анх бичиг үсэггүй үедээ өөрийн үзэл бодлыг бусдад дамжуулах шаардлагаас үүдэж шүлэг үүссэн гэж хэлж болно. Учир нь хүн өөрийн бусдад хэлэх гэсэн зүйлээ хамгийн товч тодорхойгоор хэлэхийг чухалчлах нь мэдээж хэрэг. Үүнээс үүдэн хүн төрөлхтөн шүлгийн үндсэн шинжийг товч тодорхой байх хэмээн ухаарчээ. Хүний үзэл санааг илэрхийлэх зорилготой тул шүлгийн бүх авиа, үг, өгүүлбэр тодорхой утгыг тээж, эхний авианаас дараагийн үг, тухайн үгээс дараагийн холбоо хоршоо, тэрхүү холбоо хоршооноос өгүүлбэр бүхий шүлгийн мөр, эхний мөрнөөс дараагийн мөр, улмаар бадаг үүснэ. Энэ нь шүлгийн эхний мөрийг нь хэлэх юмуу санахад л тухайн мөрнөөс дараа дараагийн мөр, бадаг ундраад үргэлжлэх зүй тогтлоор бичигдсэн байдаг гэсэн үг. Энэ бол нүүдэлчин монголчуудын шүлгийн үндсэн онцлог юм. Учир нь эрхэлж ирсэн нүүдлийн мал аж ахуй, аж амьдралын хэвшлээс үүдэн монголчуудын шүлэг өдөр тутмын үйл ажиллагаанаас нь ундрган гардаг билээ. Өөрөөр хэлбэл өдөр тутмын энгийн мэндчилгээнээс эхлүүлээд тэдний бүх зан үйл шүлгээр дамжигдана. Мөн хоорондоо үл ойлголцох овог аймгуудын дайн дажнаас үүдэн ямар нэг хэл мэдээг бичгээр бус аман шүлгйн хэлбэрээр дамжуулж ирсэн уламжлалтай. Ийм хэл мэдээг монголчууд “эмээлийн дуу” хэмээн нэрлэж заншсан байна. Энэ утгаараа монгол шүлгийн үндсэн онцлог аман шүлэг найрагтаа хадгалагдан үлджээ. Эхний мөрөөс дараа дараагийн мөр, бадгууд үргэлжлэн ундрах тул эхний мөртэй дараагийн мөр нь, эхний бадагтай дараагийн бадаг нь үеүүд болоод айзам хэмнэлийн хувьд ижилсэж, нарийн чанд холбоцоор эхэн, дунд, адагтаа холбогдоно.

Уран зохиолын үндсэн гурван төрлийн нэг болох яруу найргийн буюу шүлгийн үндсэн нэгж болох бадгийн зүй тогтол, онцлог шинжийг нарийвчлан судлах нь туурвисан үндэстнийх нь шүлгийн түүхэн хөгжил хувьсал, тогтолцоог тодруулахад зохих хувь нэмэр болно. Улс үндэстэн бүрийн соёл сэтгэлгээний онцлогоос үүдэн бадгийг хэдэн ч мөрөөр бүтээж болдог байна. Гэхдээ бадгийг үүсгэх гүн ухааны тулгуур ойлголт байх нь мэдээж хэрэг. Бидний үзэж байгаагаар монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж нь хоёр мөр шүлэг буюу хос уянга юм.

Хос уянга нь хоёр мөрөөс бүрдэж нэг цогц утга илэрхийлэх зүйл. Монгол хүний аж амьдралын соёл, бэлгэдэлт сэтгэлгээгээр бол бүх зүйл хоёрын хослолд оршино. Өөрөөр хэлбэл хоёр бол оршихуйн бэлгэдэл болдог байна. Арга билиг хоёр, тэнгэр газар хоёр, өдөр шөнө хоёр, өглөө орой хоёр, аав ээж хоёр, ах дүү хоёр, эр эм хоёр гэх мэтээр бүх зүйл хоёрын хослолд байдаг байна. Иймд нүүдэлчдийн ухаарлаар хоёр бол арга билиг, эв нэгдлийн илэрхийлэл. Нөгөө талаар хоёрын тоо тэгш тооны тэнхлэг үүсгэдэг¹ байна. Ертөнцийн бүх зүйл хоёрын шүтэлцээнд оршино гэсэн энэ үзэлдээ тулгуурлан хоёр мөр шүлгэнд хорвоо бүхлээрээ багтах боломжтой гэж нүүдэлчид ухаараад хос уянгыг шүлгийнхээ бадгийн үндсэн нэгж болгож томьёолжээ. Хорвоогийн мөн чанарыг хоёр мөр шүлгээр илэрхийлэх боломжтой гэж ойлгож байсны нэгэн адил хорвоогийн бүх хөг аялгууг хоёр утастай хөгжмөөр хөгжимдөх боломжтой гэж үндэсний хөгжим морин хуураа хоёр утастай хийсэн ард түмэн, монголчууд. Эрт цагаас дорно, өрний олон улс үндэстэн мал амьтан дөрвөн хөлийнхөө алхаа гишгээгээр явдагт суурилж шүлгийн үндсэн нэгж болох бадгаа мал амьтны оршин байх аргын нэгэн адил дөрвөн шадаас бүрддэг гэж үзэж байсан бол монголчууд мал амьтаныг биш хүнийг, хүний хөгжлийг илүүд үзэж, хүний хоёр хөл дээрээ явах нь хамгийн төгс зохицол гэж ойлгоод шүлгийн бадгийн үндсэн нэгжээ хоёр мөрөөр буюу хос уянгаар томьёолж байсан байхыг ч үгүйсгэх аргагүй.

Судлаачдын үзэж байгаагаар монгол шүлгийн хамгийн эртний хэлбэр нь зан үйлээс улбаатай дом шившлэг, бэлгэ дэмбэрлийн үг, дуу (хөдөлмөрийн дуу, ардын урт болоод богино дуу)-ны шүлэг ажээ. Эртний шүлгийн энэ хэлбэр түүхэн хөгжлийнхөө явцад зүйр цэцэн үгсээр төгөлдөржин боловсроод эртний болоод орчин үеийн уран зохиолд уламжлагдан хувьсаж хөгжсөөр ирсэн түүхтэй. Тиймд монгол шүлгийн эртний төрөл зүйлүүдийн ерөнхий бүтэц зүй тогтлыг ажиглавал ихэвчлэн хоёр мөр буюу хос уянгаас бүрдэж байна.

Дом шившлэг: Эртний хүмүүс үг ид шидтэй гэж ухаардаг тул үгийн ид шидийг ашиглан аливаа саад бэрхшээлийг амар хялбар, гарз хохиролгүй даван туулах үүднээс үгийг шившин хэлдэг байжээ. Тэр шившсэн үг нь сэтгэлгээний нь илэрхийлэл тул тодорхой дэс дараа, зүй тогтолтой байв. Энэ зүй тогтол нь эртний монгол шүлгийн ерөнхий зүй тогтол буюу бадаглалын тогтолцоог харуулж байдаг байна. Тухайлбал, эртний хүмүүс хүн бүрт өөрийн гэсэн од байдаг, тэр хүнийг үхэхээр од нь харвадаг гэж ухаардаг тул тэнгэрт од харвахыг харвал:

Тэнгэрийн од харваснаас биш

Миний од харваагүй

Түй Түй Түй

(Цэрэнсодном Д. 2012:32) гэж шившлэг хэлдэг байжээ. Өөрөөсөө ямар нэг муу муухайг зайлуулах утга илэрхийлэхдээ эхний мөрөнд тэнгэрийн од харваж байгаа үзэгдлийг хамгийн товч тодорхой илэрхийлсэн бол хоёрдугаар мөрийг нэгдүгээр мөрийн бүтэцтэй адилтган газрын буюу өөрийнхөө үйлийг зэрэгцүүлэн илэрхийлсэн байна. Нэгдүгээр мөрийн бүтэц хоёрдугаар мөрөнд яг адил давтагдаж эн зэрэгцүүлэл үүсгэжээ. Энэ нь монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж болох хос уянгын бүтэц эн зэрэгцэх зарчимтайг харуулж байна. Тэгвэл, мал хөнгөлөхөд:

¹ <https://prezi.com/p4rgpohjrtq/presentation/>

*Өднөөс хөнгөн
Сумнаас хурдан болог
Хурай хурай, дүр, дүр*

(Цэрэнсодном Д. 2012:31) хэмээн домнодог байна. Хөнгөлсөн мал хурдан түргэн эдгээрэй гэсэн утга илэрхийлсэн энэ шившлэгийн шүлгийн бүтэц нь өд, сумны хөнгөн, хурдан шинжийг адилтган эн зэрэгцүүлэл үүсгэсэн байна. Гэвч цаана хөнгөн, хурдан шинжтэй өд сумтай, зассан малыг адилтган эн зэрэгцүүлсэн хийсвэр утга илэрхийлсэн байна. Хүний нүдэнд өвдөг гарахад:

*Өвдөг гарвал өвдөгийн чинээ гар
Өвдөг гарахгүй бол хатаж хоцор*

Эм дом, эм дом (Цэрэнсодном Д. 2012:29) хэмээн домнодог байна. Нүдэнд өвдөг гарвал хүний өвдөгийн чинээ том гарчих, тийм том гарч чадахгүй бол эдгэрч эрүүлж гэсэн санааг эн зэрэгцсэн хоёр мөрөөр шүлэглэн илэрхийлсэн байна. Ийнхүү монгол шүлгийн эртний хэлбэр болох дом шившлэгийн шүлгүүд ихэвчлэн хос мөрөөр бадагладаг байна. Нэгдүгээр мөрийн бүтэц хоёрдугаар мөрөнд шууд давтагддаг тул хос уянгын хоёр мөр эн зэрэгцэх зарчимтай. Энэ нь нэгдүгээр мөрөндөө байгаль, нийгмийн ямар нэг ухагдахууны мөн чанарыг хамгийн товч тодорхойгоор илэрхийлээд түүнтэй хүний ямар нэг шинж чанарыг адилтган зүйрлэж буюу захирах захирагдах харьцаанд бус зэрэгцэн ижилсэх харьцаагаар шүлэглэдэгтэй холбоотой ажээ. Харин монгол дом шившлэг ихэвчлэн төгсгөлдөө “хурай хурай, дүр дүр, эм дом эм дом” гэх зэрэг сул үгсийг авсан онцлог харагдаж байна. Энэ сул үгс нь нэгдүгээрт, “цаашаа бүр холд, наашаа бүр ойрт, эдгээж сайн бол” гэх зэргээр тухайн дом шившлэгийн утгыг гүнзгийрүүлэн илэрхийлсэн, хоёрдугаарт, дом шившлэгээ цаашид үргэлжлэх утгатай холбоос болсон байдаг байна.

Бэлгэ дэмбэрлийн үг: Зан үйлийн аман зохиолд маш эртний утга илэрхийлэх төрлийн нэг бол бэлгэ дэмбэрлийн үг юм. Учир нь монгол хүн үг энергитэй гэж эртнээсээ ухаардаг тул аливаа сайн муу зүйлийг үгсийн онч мэргэнээр шүлэглэн илэрхийлдэг жамтай. Тухайлбал, үрс гаргах юм уу унага тамгалж байх үед гүүн зэлэн дээр ирсэн зочин,

*Ногтолсон унага чинь
Ногтруунаас олон
Зэллэсэн унага чинь*

Зээр гөрөөснөөс олон болог (Цэрэнсодном Д. 2012:40) хэмээсэн бэлгэтэй сайхан үг хэлнэ. Мөн хурдан морины уяан дээр ирсэн зочин,

Хүлэг нь хурдан

Хүүхэд нь хөнгөн байг (Цэрэнсодном Д. 2012:40) гэсэн үг хэлнэ. Энэ мэтээр монголчуудын бүх үйл хэрэгт хэлдэг тусгай тусгай бэлгэ дэмбэрлийн үгс байна. Энэ үгс нь ихэвчлэн хоёр мөр шүлэг байдаг онцлогтой. Хоёр мөр шүлгийн үгс хоорондоо үе, өргөлт, хэм хэмнэлийн хувьд адилхан байна. Энэ нь монгол аман зохиол дахь бэлгэ дэмбэрлийн үгс, ерөөс монгол аман зохиолын эртний төрөл зүйлүүд хос уянгаас бүрддэг. Хос уянгын хоёр мөр хүний өгүүлэхүйн эрхтний зүй тогтолтой нийцж, тодорхой хэмнэлд захирагдах тул үе, өргөлтийн хувьд ижил байж эн зэрэгцэх зарчимтай болохыг харуулна.

Дууны шүлэг: Монгол шүлгийн онцлогийг хадгалсан эртний өвөрмөц төрөл бол дууны шүлэг. Монголчууд эртнээс дуу хуурт онцгой ач холбогдол өгч ирсэн түүхтэй. Монгол дуу дотроо олон төрөл зүйлтэй ч эх үрийн элбэрэл хайрыг илэрхийлсэн “Бүүвэй аялах” (хүний), “Тойглох” (хонины), “Цүүцүүлэх” (ямааны), “Турайлах” (адууны), “Хөөвлөх” (үхрийн), “Хөөслөх” (тэмээний) гэсэн зан үйлийн холбогдолтой дуунууд нэн эртний ул мөрийг хадгалсан, тэр хэмжээгээрээ онцгой ач холбогдолтой бүтээлүүд юм. Тухайлбал, “Бүүвэйн дуунд”,

Ангир шувууны дэгдээхэй шигээ
Алсаас ээжийгээ дуудаад байна уу даа
Ээ бүүвэй, ээ бүүвэй, ээ бүүвэй
Хараацай шувууны дэгдээхэй шигээ
Харцан дундуураа дуудаад байна уу даа
Ээ бүүвэй, ээ бүүвэй, ээ бүүвэй
Хайртай хонгор үр минь дээ, чи
Халуун манцуйндаа унтаарай даа

Ээ бүүвэй, ээ бүүвэй, ээ бүүвэй² хэмээн шүлэглэдэг билээ. Ээж хүн нялх балчир хүүхдээ уяраан тайвшруулах зорилгоор аялан дуулдаг дууг бүүвэйн дуу гэж монголчууд хэлж заншсан байна. Бүүвэйн дуу гэдэг нь “бүү ай” гэсэн утга илтгэдэг билээ. Энэ “Бүүвэйн дуу”-ны шүлэг хос уянгаар бадагласан байна. Эхний мөрөнд ээж хүн амьтны тэр дундаа жигүүртний дэгдээхэйн тухай өгүүлээд хоёрдугаар мөрөнд өөрийнхөө үр хүүхдийн тухай өгүүлэхдээ хоёр мөрийг хооронд нь харьцуулан жишиж шүлэглэсэн байна. Хоёр мөрийг хооронд нь харьцуулан жишсэн учир мөр хооронд тэгш хэм үүссэн, мөн эх хүн далд зөн совин хүсэл мөрөөдлөөрөө үр хүүхдээ жигүүртний дэгдээхэй шиг хурдан өсөж том болоод жигүүртэй мэт амжилт бүтээл гаргаж амьдрахыг хүссэн хүслээ илэрхийлсэн нь далд харьцуулал, тэр хэмжээгээр мөр хооронд далд зэрэгцүүлэл үүссэн байна. Монгол эх хүн ертөнцийн хамгийн төгс хэм хэмнэлийн илэрхийлэл бол бүүвэйн дуу гэж ойлгодог. Бүүвэйн дуунд хэм хэмнэл, аялгуу байгаа тул бяцхан хүүхэд түүнийг мэдэрч чадаж байгаагийн илэрхийлэл нь тухайн хүүхдийн амгалан тайван болох үйл явц юм. Судлаач Л.Түдэв “Бүүвэйн дуунд уясаж өссөн хүүхэд өр нимгэн, сэтгэл зөөлөн, зүрх энэрэнгүй хүн болдог нь нэгэнт шалгарсан нотолгоо шаардахгүй үнэн”³ гэж өгүүлсэн байдаг. Бүүвэйн дуу төгс хэм хэмнэлтэй тул хүүхдийн зүрхний цохилт, амьсгалын хэмнэлийг тогтворжуулан тайвшруулах увдистай гэж настайчууд ярилцах нь худал зүйл биш болтой.

Зүйр цэцэн үг: Хос уянгын сонгодог жишээ бол зүйр цэцэн үгс юм. Тухайлбал,

Зүйргүй үг байдаггүй

Зүйдэлгүй дээл байдаггүй гэж өгүүлсэн нь монгол хүний хувьд ямар ч зүйлийн мөн чанар, утга агуулгыг илэрхийлэхэд зүйрлэн шүлэглэх нь хамгийн шилдэг арга, ямар ч дээлийг /дээл нь монгол гадуур хувцасны хамгийн шилдэг загвар “etalon”-юм/ зүйж, эсгэж оёхоос өөр аргагүйг өгүүлжээ. Энэ зүйр үгийн санаа монгол шүлгийн хувьд нэг мөрөөс бадаг бүрдэх боломжгүй гэсэн үзлийг давхар баталж байна. Мөн,

Ганц хүн айл болдоггүй

Ганц мод гал болдоггүй (Цэрэнсодном Д. 2012:53) гэсэн зүйр үг байгаа нь цаад мөн чанартаа бас л ганц мөр шүлэг болох үндэслэлгүйг харуулж байгаа хэрэг юм.

Монголын эртний бичгийн уран зохиолын гол дурсгал болох “Монголын Нууц Товчоо” зохиолд,

(§ 33) *Beye teri ütü*

De el jaqatu (Rachewiltz. 1972:18)

Ce el usun niduralu a

(§ 72) *Ceügen cilawun cewürelu a* (Rachewiltz. 1972:28) зэрэг хоёр мөрт шүлгээр ончтой уран дүрсэлсэн шүлэглэл түгээмэл байна. Шүлэг туурвигч үндэстнийхээ оюун сэтгэлгээний үнэт өвийг тээгч тул аливаа үндэстний оюун санааны гол мэдээ мэдээлэл шүлэгтээ хадгалагдаж байдаг. Тухайлбал, “Монголын Нууц Товчоо” бүтээлээс эш татсан эхний хос уянгад олон жижиг овог аймгуудыг нэгэн захиргаанд нэгтгэн хүчирхэг гүрэн байгуулах гэж зорьж байсан нүүдэлчин монголчуудын олон зуун жилийн хүсэл мөрөөдлийн ой санамжийг товч тодорхой

² Энэ өгүүллийг бичигч би бээр ээжийнхээ дуулдаг байсан “Бүүвэйн дуу”-ны хувилбарыг энд иш татав.

³ <http://news.gogo.mn/t/91613>

урнаар илэрхийлсэн байгаа бол сүүлийн жишээнд их үйлийг бүтээхэд эе эв эвдрэх шиг гарзтай зүйл үгүйг өгүүлсэн байна.

Дээр өгүүлсэн зүйр цэцэн үгүүд хоёр зүйлийг хооронд нь харьцуулан дотоод мөн чанарыг нь илэрхийлэхэд чиглэгджээ. Харьцуулал бол танин мэдэхүйн үндсэн эх сурвалж. Хүний харьцуулах сэтгэлгээ нэг учир харьцуулагдах зүйлс тодорхой эрэмбэ үүсгэх нь гарцаагүй. Монгол зүйр цэцэн үгэнд ихэвчлэн хоёр зүйлийг харьцуулдаг байна. Монгол зүйр цэцэн үгэнд хоёр зүйлийг харьцуулж, хоёр мөр шүлгээр илэрхийлэх тул харьцуулагдаж байгаа хоёр зүйлд шүлгийн нэг нэг мөр адилхан зориулагддаг гэж хэлж болно. Тиймд хоёр мөрийн бүтэц зүй тогтол адил байдаг байна. Нөгөө талаас хүний өгүүлэхүйн эрхтний зүй тогтолд тааруулагдаж шүлгийн мөрүүд эрэмблэгдэх тул нэг цогц утгад зангилагдсан бадаг айдсам, хэм хэмнэлийн хувьд ижил болдог зарчимтай байна.

XIII зууны үеийн Монголын уран зохиолын чухал дурсгалуудын нэг болох “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир” зохиолд:

Ūge-tei bolbasu ūči čī

Qosiya-tai bolbasu qolbu čī (1959:41) гэж өгүүлсэн байна. “Хэлэх үг байвал хэл, холбох хошоо байвал холбо” гэсэн утга тээсэн ч, “үгийг өчдөг, хошоог холбодог” юм гэсэн санаа давхар харагдана. Түүгээр ч барахгүй бидний яриад байгаа хоёр мөр шүлэг буюу хос уянгыг “хошоо” гэж эртний монголчууд нэрлэдэг байсан нь ойлгогдохын зэрэгцээ үг гэдэг бие даасан ойлголтын зэрэгцээ хошоо гэдэг мөн бие даасан зүйл байсан нь батлагдаж байна. Дээрх жишээ баримтаас үзвэл үг холбож хошоо болгодог журмаар монгол шүлэг бичигддэг байжээ. Ариа нийлж үг үүсгэнэ, үг хоршиж хошоо үүсгэнэ, хошоо холбогдож мөр үүсгэдэг, мөр өөр мөртэй эн зэрэгцэж хос уянга бүтээдэг зарчимтай байна.

Дээр өгүүлсэн зүйлийг нэгтгэн үзвэл хос уянга буюу хошоо нь монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж ажээ. Иймд хос уянга буюу хошоо нь монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж мөн болохын хувьдаа монгол үндэстний шүлгийн уугуул бие даасан төрөл зүйл болно гэсэн дүгнэлт урган гарч ирж байгаа төдийгүй монголчуудын аман болоод бичгийн яруу найргийн анхдагч нэгж болж байна. Монгол шүлгийн дотоод зүй тогтлоос ийм дүгнэлт урган гарч байгаа тул хос уянга буюу хошоо нь Японы хайкү, Солонгосын шижү, Грекийн дистих, Өрнөдийн сонет... зэрэгтэй нэгэн адил бие даасан төрөл зүйл юм. Үүгээр ч зогсохгүй хос уянга буюу хошоо нь хайку, шижү, дистих, сонет... зэрэгтэй нэгэн адил бүтэц байгуулалтаараа чанд зохион байгуулалтыг эрхэмлэдэг ч утга агуулгыг илэрхийлэхийн тал дээрээ чөлөөт үзлийг эрхэмлэсэн байгаагийн зэрэгцээ зөвхөн монгол төдийгүй ерөөс шүлгийн бүтцийн ерөнхий бүх шинж төрх, арга билгийн зохилдолгоог агуулсанаараа ихээхэн давуу талтай нь харагдаж байна.

Хос уянгын өөр нэг онцлог бол нэгдүгээр мөрийн үлгэрээр хоёрдугаар мөр бүтэж байна. Энэ нь нэгдүгээрт, монгол шүлэгт эхний мөр нэн чухал үүрэгтэйг, хоёрдугаарт, эхний мөр дараагийн мөрийн загвар болдог энэ зарчимаас үүдэн холбоцын хувьд эхний буюу толгой холбоц бусад холбоцуудаа тэргүүлэх үүрэгтэйг, гуравдугаарт, ерөөс монгол хүний сэтгэлгээ аливаа зүйлийн эхлэлийг нэн чухалчилж үздэгийг харуулна. Хоёр мөрийн бүтэц ижил тул мөр бүрийн үе, үгийн тоо, хэм хэмнэл ижил байх нь мэдээж хэрэг. Тиймд хос уянгын хоёр мөрийн үгс хоорондоо ижилсэн, эсрэгцсэн зэрэг ямар нэг харьцаагаараа шүтэлцэж тэр хэмжээгээрээ шүлгийн уран сайхан, утга агуулгыг яруу болгож байна. Монгол хүний арга билгийн шүтэлцээт сэтгэлгээний хүрээнд хэл нь ч хоёрын хослолыг илэрхийлэх үгээр төгс баяжсан байдаг байна. Монгол хэлний арга билгийг илэрхийлэх үгс бие биенээ захирах захирагдах харьцаанд оршдоггүй, хос уянгын хоёр мөрийн бүтэц ижил тул ямар ч үед эн зэрэгцэх харьцаанд оршдог байна.

Хос уянгыг бүтээх үгс нэгээс нөгөө нь урган хоорондоо өвөрмөц нарийн холбоо хамааралтай байгаа нь нүүдэлчдийн өдөр тутмын ажил, ахуй соёл бүгд хоорондоо шүтэлцээ

холбоотой байдагтай холбоотой байхыг үгүйсгэх аргагүй. Учир нь хос уянгын хоёр мөрийн бүтэц ижил байж эн зэрэгцэх зарчимтай ч хоёр мөрийн үгс өөр өөрийн утгыг чөлөөтэй илэрхийлэх зарчимтай байгаа нь нүүдэлчдийн сэтгэхүй, ажил үйл дахин давтагдах адил шинжтэй ч хэзээ ч бие биеэндээ саад болохгүй эрх тэгш байх зарчимаар үргэлжилдэг сэтгэхүйтэй холбоотой.

II. МОНГОЛ ШҮЛЭГ ДЭХ ДӨРВӨН МӨРТ ШҮЛГИЙН БҮТЭЦ ТОГТОЛЦОО

Хоёрын тооны үржвэр бол дөрөв. Хоёрын тоо арга билиг хийгээд тэгш хэмийн бэлгэдэл. Тиймд дөрвийн тоо нь арга билиг хийгээд тэгш хэмийн үржвэр. Өөрөөр хэлбэл дөрвийн тоо нь хэм тэгш тэгшрэлийн илэрхийлэл болж, тэр утгаараа бат бөхийн бэлгэдэл утга илэрхийлнэ. Монголчууд “дөрвөн зүг найман зовхис”, “дөрвөн хөлтэй шийр шиг, дөрвөлжин зоотой морь шиг” гэх зэргээр дөрвийг бат бэхийн бэлгэдэл утгаар ойлгодог байна. “Монголын Нууц Товчоо” тэргүүтэй түүхэн сурвалж бичгүүдэд ч Чингис хааны ялан дийлж, мөнх оршихын бэлгэдэлт “хараа ихт дөрвөн хөлт хар сүлд”, Зэв, Сүбээдэй, Зэлмэ, Хубилай нарын “эрдэнэт дөрвөн сэцэд”, “харилтгүй дөрвөн баатар” гэх мэтээр дөрвийн тоогоор бат бөх байх, өнө мөнхөд удаан үргэлжлэх, үнэнч найзалж нөхөрлөх зэрэг утгыг илэрхийлсэн байна. Дөрвөн улирал, дөрвөн зүг зэрэг нь бүрэн дүүрэн гэсэн утга илэрхийлнэ.

Монгол хүний нийтлэг сэтгэлгээгээр бол хоёр дөрвийг үүсгэнэ. Өөрөөр хэлбэл хоёроос дөрвийн утга, хэмжээс бий болно. Энэ томъёоллоор хоёр мөр шүлэг үндсэн бүтэц тогтолцоогоо хадгалж дөрвөн мөрт шүлгийг үүсгэдэг байна. Энэ утгаараа монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж нь хос уянга буюу хошоо мөн тул монгол шүлэг бүтэхдээ хос уянга буюу хошооны ерөнхий бүтцийг эвдэлгүйгээр давтан өрсөн, нэмэн дэлгэрүүлсэн хэлбэртэй байдаг. Дөрвөн мөрт шүлэг ч ихэвчлэн энэ загвараар бүтэж байна.

Монгол аман зохиолын шүлэглэсэн эртний төрөл зүйлүүд ихэвчлэн хоёр мөрт буюу хос уянгаар бадагласан байна. Энэ нь хос уянга монгол шүлгийн бадгийн үндсэн нэгж болохыг батлан харуулахын зэрэгцээ эртний монгол шүлгийн үндсэн онцлогийг илэрхийлж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл эртний монгол шүлэг хүний харьцуулан жиших сэтгэлгээнд суурилсан товч тодорхой хошоо байжээ. Энэ нь нүүдэлчдийн ар араасаа ундарсан шахуу хөдөлмөрийн хувиар, түүнээс үүдсэн асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх сэтгэлгээнээс үүсэлтэй байх талтай. Гэтэл аман зохиолын хожуу үүссэн төрлүүд, бичгийн уран зохиолын шүлгүүдийг ажиглавал ихэвчлэн дөрвөн мөрөөр бадагласан онцлог харагдаж байна. Энэ нь монгол шүлгийн бадаглалын хөгжлийг харуулж байгаа хэрэг.

Дөрвөн мөрт шүлгийн сонгодог жишээ бол монгол ардын дууны шүлэг юм. “Дууны шүлэг нь аялгуу хөгжмийн хэмнэлд яв цав нийцсэн байх тул юуны өмнө мөр бадгийн толгой, сүүл холбоц, дотоод холбоц, утга лавируулан давтах эн зэрэгцүүлэлтийн аргаараа бусад яруу найргийн төрлөөс гойд ялгаатай гэж хэлж болох юм.” (Цэрэнсодном Д. 2012:203) Энэ нь дууны шүлэг мөрийн хувьд үгс нь бие биенээсээ шууд ундарсан, бадаглалын хувьд гадаад, дотоод холбоцуудаар гүн нарийн холбогдсон байх тул өөрөөс нь хөг аялгуу нь эгшиглэсэн яруу сонсголонтой байдаг онцлогтой. Энэ утгаараа дууны шүлэг монгол шүлгийн бадгийн бүтцийн үндсэн онцлогийг тодорхой хэмжээгээр хадгалдаг билээ. Нөгөө талаас утга агуулгын хувьд “дуу бол хамт олны эв нэгдэл, үзэл санаа, гоо сайхны мэдрэмжийг илэрхийлэх чадамжаараа ардын аман зохиолын аль ч төрлөөс давуутай байдаг байна.” (Цэрэнсодном, 2012:200) Дууны шүлэг ая айзам, хэм хэмнэлд захирагддаг тул нарийн бүтэцтэй байдаг. Тухайлбал, “Нарийн сайхан хээр” хэмээх ардын богино дуунд,

Нарийн сайхан хээрийгээ

Аргамжин сойж унаарай

Настай болсон ээжтэйгээ

Намрынхаа сард золгоорой ...(Цэрэнсодном Д. 2012:201) гэж шүлэглэсэн байна.

Тэгвэл “Эрдэнэ засгийн унага” гэх уртын дуунд,

Эрдэнэ засгийн унага

Эрэмгий болоод жороо доо

Элст манхан нутагтай

Эмгэн буурал ээжтэй дээ ... (2005:124) гэжээ. Монгол ардын ихэнх дууны шүлгийн бадаг ийм бүтэцтэй байна. Өөрөөр хэлбэл дөрвөн мөр шүлгийн мөрүүд зэрэгцсэн байрлалаараа хоёр хоёроороо нэгдэн ижилсэх ч нийлээд нэг цогц утга санааг илэрхийлдэг байна. Харьцуулах, ижилсэх, зэрэгцэх зэрэг хоёрын хослолоор бүтэх хос уянгын эхний мөрд байгаль, нийгмийн ямар нэг амьтай, амьгүй зүйлийн мөн чанарыг өгүүлээд дараагийн мөрд нь хүний мөн чанарыг түүнтэй харьцуулан жишиж шүлэглэдэг бол дөрвөн мөр шүлгийн эхний хоёр мөрд аливаа нэг зүйлийн мөн чанарыг, сүүлийн хоёр мөрд хүний ямар нэг шинжийг өгүүлж бадгийн мөрүүдийг хоёр хоёроор нь ижилсүүлэн зэрэгцүүлж шүлэглэж байна. Уран зохиол бол хүний мөн чанарыг нээхэд чиглэдэг зүйл. Тиймд ардын дууны шүлгийн дөрвөн мөрөөр бадагласан шүлэгт хүний ямар нэг шинжийг бусад ямар нэг зүйлийн шинжтэй харьцуулан жишиж, дундаас нь хүний мөн чанарыг зөвөөр нээхэд чиглэгдэж байна. Хос уянгатай харьцуулахад дөрвөн мөр шүлэгт илэрхийлэх агуулга илүү тодорхой гарах боломжтой ч шүлгийн урлалд илүү төвөгтэй байдал үүсэх талтай. Учир нь илүү олон үгийн хослолоор, илүү олон өгүүлбэрээр санааг илүү гүн илэрхийлэх бололцоотой ч олон үгсийг нарийн чанд эрэмбэлж зүй тогтол үүсгэх нь төвөгтэй байх нь ойлгомжтой. Энэ нь нөгөө талаас монгол шүлгийн урлалд үүссэн ололт амжилтыг харуулж байна.

“Монголын Нууц Товчоо” зохиолд дөрвөн мөрөөр бадагласан,

(§ 96) *Qar buluqan daqu-yin qari'u*

Qaqacaqsanulus-i cinuqamtutqajuōksū

Buluqandaqu-yin qari'u

Butaraqsanulus-i cinubūgūtke[l]dūjūōksū (Rachewiltz. 1972:37) зэрэг цөөн жишээ байна. Гэтэл хожуу үеийн түүхэн сурвалж бичгүүдийн ихэнх шүлэг дөрвөн мөрөөр бадагласан байна. Тухайлбал, Лувсанданзаны “Алтан товчид:

Altan bey-e-ben amusu kemebesū

Aqu törū minu aldayujai

Būtūn bey-e-ben amusu kemebesū

Bürin ulus minu samturayujai

Altan bey-e minu aljiyabasu aljiyatuyai

Aqu törū minu būū aldaratuyai

Būtūn bey-e minu jobobasu jobatuyai

Bürin ulus minu būū samturatuyai (1990:109) хэмээн бадагласан байна.

Бичгийн уран зохиолын эдгээр жишээ баримтууд нь уламжлалт хос уянгад суурилсан бадаглалын зарчмыг нарийн баримталсан ч агуулгад түлхүү анхаарал хандуулах болсон нь илт харагдаж байна. Өөрөөр хэлбэл энэ үеийн шүлэг найраг утга агуулгыг тэргүүн эгнээнд чухалчлан утгыг илэрхийлэх бүтцийг уламжлалт аргаар бүтээж байсан байна. “Сурсан зүйлийг сураар боож болохгүй” нь үлгэрээр бичгийн уран зохиол дахь шүлгүүд тухайн цаг үеийн онцлогоос үүдэн агуулга талаа чухалчлах болсон ч уламжлалт шүлгийн бүтэц шууд л уламжлагдан шинэчлэгдэж байсан хэрэг. Үүнийг дээрх жишээ шүлэг дэх мөр хоорондын үе, үгийг тааруулах, холбоц нийлүүлэх үүднээс ашигласан аргуудаас харж болно. Өөрөөр хэлбэл, уламжлалт хос уянгад суурилсан дөрвөн мөрт шүлгүүд монголын эртний бичгийн уран зохиолд зонхилох шинжтэй байсан ч цаг үеийн онцлогоос үүдсэн бий болсон агуулга, үзэл санааг чухалчлах үйл хэргээс үүдэн дөрвөн мөрт бадгийн бүтцэд тодорхой өөрчлөлт орох шинж зарим талаар бий болжээ.

Хос уянгын бүтцийг уламжлан, тэр бүтцийг шууд угсруулан өрж дөрвөн мөрөөр нэг бадаг бүтээх үйл орчин үеийн уран зохиолд чухал байр суурьтай байгааг захын жишээнээс харж болохоор байна. Жишээлбэл, Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэгт,

*Хэнтий, Хангай, Саяаны өндөр сайхан нуруунууд
Хойт зүгийн чимэг болсон ой хөвчин уулууд
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд*

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

*Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд
Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд
Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд
Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд*

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон ... (2006:89) гэж шүлэглэсэн бадгууд буй.

Энэ хоёр бадаг шүлгийн эхний хоёр мөр, сүүлийн хоёр мөрөөрүүд хоорондоо өргөлттэй, өргөлтгүй үгийн тоо хийгээд дотоод хэмнэлээрээ нягтран холбогдож нэг цогц санаа илэрхийлж байгаа нь хос уянга ерөнхий бүтцийнхээ дагуу өрөгдөн угсрагдаж дөрвөн мөрт шүлэг буюу нэг бадаг үүсгэдэг зарчмаар шууд туурвигдсаныг харуулж байна. Тэгвэл Б.Явуухулангийн “Туулын шугуй” шүлэгт,

Туулайн гүйдэл шиг салхинд

Туулын шугуй найгана

Уулын согоо шиг хүүхэнд

Хайрын сэтгэл дасна

Хээрийн салхинд Туул минь

Тахийн зоо шиг бидэрлэнэ

Хайрын хүчинд сэтгэл минь

Тэнгэрийн заадас шиг гэрэлтэнэ... (1985:210) хэмээн бадаг бүрийн нэг гуравдугаар мөрүүд, хоёр дөрөвдүгээр мөрүүд үе, өргөлт, хэмнэлээрээ ижилсэж толгой, дунд, сүүл холбоцуудаар холбогдсон нь эхний хоёр мөр, сүүлийн хоёр мөр тус бүрдээ утгаараа холбогдож, хоорондоо зэрэгцэх харьцаа үүсгэн бичигдсэн нь хос уянгын буюу хошоог ерөнхий загвараар нь угсруулан өрж нэг бадаг үүсгэснийг илтгэнэ. XX зууны монголын уран зохиолын хоёр гол төлөөлөгч болох Д.Нацагдорж, Б.Явуухулан нарын “Түүвэр зохиол”-уудад орсон дөрвөн мөрт шүлгүүдийг ажиглахад 60 орчим хувьд нь хос уянгыг дэлгэрүүлэн өрсөн дээрх загвараар бүтээгдсэн байгаа нь хос уянгын үндсэн загварыг ашиглаж шүлэглэх урлал өдгөө хүртэл уламжилж ирснийг гэрчилж байна. Монгол шүлгийн бадаглалын энэ үндсэн зарчим цаашид ч үргэлжлэх нь тодорхой.

XVII зууны үеэс монгол шүлгийн бадаглалын түүхэн хөгжилд тодорхой өөрчлөлтүүд бий болсон бололтой. Өөрөөр хэлбэл уламжлалт хос уянгын зарчмаар туурвигдсан дөрвөн мөрөөр бадагласан шүлэг эрчимтэй бичигдсэний зэрэгцээ ар араасаа угсарсан дөрвөн мөрөөр урлаж нэг бадаг бүтээх болсон онцлог харагдаж байна. Тухайлбал, Халхын Цогт хун тайжийн туурвисан “Дуутын хадны бичээс”(1621) шүлэгт,

Дээд тэнгэр хааны ахуй хийгээд

Дэлхий дахь хан богдсын ахуй газар

Дээр дорын ялгал боловч

Жаргал, хайрлал хоёрын агаар нэгэн буй... (1959:41) хэмээн шүлэглэсэн байна. Энэ бадгийн эхний хоёр мөр тодорхой харьцуулалтад суурилсан эн зэрэгцэх зарчмаар бүтсэн ч сүүлийн хоёр мөрөндөө хоёул шууд хамааралтайгаар бичигдсэн байна. Өөрөөр хэлбэл уламжлалт дөрвөн мөрт шүлэг шиг хоёр хоёр мөрөөрөө тус тусдаа хос уянга үүсгээд

хоорондоо нэгдэн найрч нэг цул утга илэрхийлсэн бус эхний хоёр мөр нь хос уянгын бүтэцтэй ч дараагийн хоёр мөр нь тус тусдаа утга тээх тул хос уянгын бүтцээр бичигдээгүй байна. Энэ нь монгол шүлгийн бадгийн хөгжилд тодорхой хэмжээний өөрчлөлт орж эхэлж байгаа завсрын үеийг харуулж байгаа хэрэг. Монгол шүлгийн бадгийн хөгжилд гарсан энэ өөрчлөлтийг XIX, XX зууны шүлгийн өв сангаас тодорхой харж болохоор байна. Өөрөөр хэлбэл уламжлалт хос уянгад суурилсан дөрвөн мөрөөр бадагласан бадаглал түүхэн хөгжлийнхөө явцад улам боловсрон хөгжихийн зэрэгцээ шинээр дөрвөн мөрөөр бадаглах зарчим бий болж нэлээд эрчимтэй хөгжжээ. Үүнийг XX зууны монголын шилдэг яруу найрагчид болох Д.Нацагдорж, Б.Явуухулан нарын шилдэг шүлгийн бадгуудын онцлогоос харж болохоор байна.

Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн “Хавар” хэсгийн эхний хоёр бадагт,

*Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар
Монголын сайхан орон дор жил жил дэлгэр
Энх улирал ханхлах дор хүний сэтгэл тэнгэр
Өвсний соёо ногоорох дор морь мал ханагар
Холхи наран ойртож хасын цасан хайлах дор
Хуучин дэлхий халагдаж хамаг юм шинэднэ
Хөхөрсөн модон цэцэглэж хүүхэд багачууд наадах дор
Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана...* (2006:134) гэж шүлэглэсэн байна.

Энэ бадгуудын мөрүүд хос уянгын адил эн зэрэгцэх зарчмаар бус толгой, дунд, сүүл холбоцоор холбогдсон ч утгын гүнзгийрлийн дагуу эхний мөрийн араас дараа дараагийн мөрүүд шууд үргэлжилсэн зарчмаар бичигдсэн байна. Тэгвэл Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ?” шүлгийн бадгууд,

*Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би:
Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт
Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд
Хоёр нүдний үзүүрт цэнхэртэх төдий тэртээд
Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би
Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би:
Цан хүүрэг савсаж үүлс ороох оргилд
Цасан ширхэг царцаж мөс болох халилд
Царгиа хүйтэн өвөл сарлагийн бух тошсон*

Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би... (1985:387) хэмээн бадаглагдсан байна. Ингэж Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн нэгэн адил утгын гүнзгийрлийг даган мөрүүд дотоод хэмнэлээрээ ар араасаа угсарч дөрвөн мөрөөр бадаглал бүтээжээ. Мэдээж дөрвөн мөртөд өмнө өгүүлсэн монголчуудын дөрвийн тоог үзэх үзэл баримтлал шингэсэн нь ойлгомжтой.

Дотоод хэмнэлээрээ эвсэж, утгын гүнзгийрлийн дагуу мөрүүд ар араасаа угсарсан дөрвөн мөрөөр бадаг бүтээхэд эхний мөрийн үндсэн загвар хоёрдугаар мөрдөө уламжлагдаад бүтцийн хувьд үндсэн үүргээ гүйцэтгэж байна гэж хэлж болохоор байна. Учир нь хоёрдугаар мөр гуравдугаар мөрөө бүтцийн хувьд дотоод хэмнэл, холбоцуудаараа шууд захирч байна. Гуравдугаар мөр нь дөрөвдүгээр мөрийнхөө эх загвар болно. Иймд хамгийн эхний нэгдүгээр мөрийн үг, үеийн тоо, холбоц аажмаар хойшоо өөрчлөгдөх нь нээлттэй болж тухайн шүлэг илүү уран сайхан, утга төгөлдөр болох үндэс бүрдэж байна. Дөрвөн мөрөөр бадагласан шүлгийн мөрүүд дотоод хэмнэл, холбоцуудаар холбогдох ч өөрийн үндсэн бүтцийг дараагийн мөрдөө улам боловсронгуй болох зарчимаар өвлүүлээд тухай бүрдээ үүргээ гүйцэтгэж байна.

Монгол шүлэг дэх хоёр ба дөрвөн мөрт шүлгийн бүтэц тогтолцоо харьцангуй тогтвортой хөгжиж иржээ. Монгол шүлэг дэх хоёр ба дөрвөн мөрт шүлэг бүтцийн хувьд тогтвортой байгаа нь шүлгийн бадаг туурвигч үндэстнийхээ сэтгэлгээний бүтэцтэй шууд холбоотойг харуулна. Нөгөө талаас шүлгийн бадаг бүтцийн хувьд тогтвортой байх нь уншигчийн хүртэх мэдрэхүйтэй зохицож оршдогтой холбоотой. Хүний сэтгэл-оюун ухаан хийсвэр олон талтай учир мөрөөс мөрийн, бадгаас бадгийн хооронд лавшран гүнзгийрсэн утгыг олон талаас нь чөлөөтэй хүлээж авч чаддаг байна. Тиймд шүлэг бол бүтцийн хувьд уншигчийн хүртэх мэдрэхүйтэй зохицож, сэтгэл-оюуныг олон талаар баясгаж, тэтгэн тэжээдэг гэж хэлж болохоор байна.

Дүгнэлт

- Шүлгийн бадаг туурвигч үндэстнийхээ соёл сэтгэлгээ, эрхэлж ирсэн аж ахуй, байгаль-нийгмийн онцлогоос үүдэн өвөрмөц зүй тогтолтой байдаг байна. Монгол шүлэг эрс тэс уур амьсгалтай дөрвөн улирал ээлжилсэн төв азийн өндөрлөгдөх нүүдлийн соёл иргэншлийн үйл амьдрал дунд ертөнцийн зүй тогтол-бүтцийн үлгэрээр хэм тэгшийн зарчимтай туурвигджээ. Монгол шүлгийн бадаг хоёр ба дөрөв, гурав ба зургаагаар голчлон бадагладаг байна. Мөн тодорхой бадаг үүсгээгүй ч дотоод холбоцуудад захируулсан чөлөөт шүлэг тодорхой хэмжээгээр хөгжиж иржээ. Чөлөөт шүлгийг задгай буюу цагаан шүлэг гэж нэрлэж заншжээ.
- Монгол шүлгийн түүхэн хөгжлөөс ажиглахад ардын аман зохиолын эртний төрөл зүйлүүд ихэвчлэн хос уянга буюу хоёр мөрт шүлгээр бадагладаг байжээ. Хос уянгыг монголчууд хошоо хэмээн нэрлэж заншжээ. Хос уянга монголчуудын хоёрыг үзэх үзэл дээр тулгуурлан үүсэж хөгжсөн байна. Монгол хүний ухаарлаар хоёр бол тэгш хэмийн төгс зүй тогтлыг илэрхийлдэг. Хоёр төвдөө тэмүүлэх буюу нэг утгад зангилагдаж байж тэгш хэм үүсгэхийн зэрэгцээ үндсэн үүргээ гүйцэтгэдэг байна. Нүүдэлчин монголчуудын соёл сэтгэлгээ хоёрыг арга билгийн шүтэлцээнд ойлгодог билээ. Арга билгийн дунд амьдрал өрнөдгийн жишгээр арга билгийн тэгш хэмт загвараар монгол шүлгийн үндсэн нэгж болох хос уянга бадагладаг байна. Хос уянгын мөр тус бүрийн өргөлттэй, өргөлтгүй үгийн тоо, үеийн тоо тэнцүү байна. Хос уянгыг бүтээх хоёр мөр тэгш хэмтэй тул бүтцийн хувьд эн зэрэгцэх харьцаанд оршиж, бие биенийгээ захирдаггүй онцлогтой. Харин утгын хувьд эхний мөрнөөс дараагийн мөр рүү гүнзгийрэн лавширдаг байна.
- Монгол шүлгийн бадаглал түүхэн хөгжлийнхөө явцад хос уянгаас дөрвөн мөрт шүлгийг үүсгэжээ. Дөрвөн мөрт шүлгийн уг язгуур нь монголчуудын дөрвийг эрхэмлэх үзэл хийгээд дөрвөн зүг буюу дөрвөн хэмжээст тэгш хэмийн загвар юм. Тодруулбал мал амьтны дөрвөн хөлийн гишгэдэл нэг цогц үйлийг илтгэхийн адил дөрвөн мөр шүлэг нь нэг цогц утга санааг илэрхийлэх боломжтой гэх үзэлтэй холбоотой ажээ. Дөрвөн мөрт шүлэг хос уянгаас үүсэлтэй тул хос уянгын бүтцийг өөрчлөлгүйгээр зэрэгцүүлэн өрөх аргаар бүтдэг байна. Өөрөөр хэлбэл хоёр хос уянга тус бүрдээ илүү нягтран нэгдээд эн зэрэгцэж, цогц утга санаа илэрхийлэх тул дөрвөн мөрт шүлгийн эхний хоёр мөрийн үе, өргөлттэй өргөлтгүй үгийн тоо сүүлийн хоёр мөрийн үе, өргөлттэй өргөлтгүй үгийн тоотой тэнцүү байж, тэр хэмжээгээрээ жигд хэмнэл үүсгэдэг байна. Хос уянга харьцуулан жиших зарчимд суурилдаг тул дөрвөн мөрт шүлгийн хоёр хос уянга ч хоорондоо харьцуулагдах зарчимтай байдаг байна.
- Монгол дөрвөн мөрт шүлгийн бадаглал хөгжлийн явцдаа хос уянга өрөгдөн хоёр хоёр мөрөөрөө эн зэрэгцэх зарчмаар бүтэхийн зэрэгцээ бадаг бүтээх дөрвөн мөр ар араасаа угсран шүлэглэгдэх аргыг үүсгэжээ. Мөрүүд ар араасаа угсран бадаг үүсгэхдээ дотоод хэмнэл, холбоцуудаар хоорондоо холбогдох ч харьцангуй чөлөөт зарчимд суурилдаг

байна. Өөрөөр хэлбэл нэгдүгээр мөр бүтцийн хувьд хоёрдугаар мөрийн эх загвар болоод үүргээ гүйцэтгэнэ. Хоёрдугаар мөр нэгдүгээр мөрөөс уламжилсан бүтцээ боловсронгуй болгоод гуравдугаар мөрдөө шилжүүлнэ. Гуравдугаар мөр хоёрдугаар мөрөөс уламжилсан бүтцээ илүү боловсронгуй болгоод дөрөвдүгээр мөрдөө шилжүүлж байна. Дөрөвдүгээр мөр нь гуравдугаар мөрөөсөө авсан уламжлалаа илүү боловсронгуй болгон зангидах зарчимтай ажээ. Энэ тохиолдолд бадгийн утга нэгдүгээр мөрөөсөө лавшран гүнзгийрсээр дөрөвдүгээр мөрийнхөө бүтцийн зангилаатай нэгдэн нийлдэг байна.

STRUCTURE OF COUPLET AND QUATRAIN IN MONGOLIAN VERSE

Every strophe of the verse has a unique identity depending on the culture, the thinking, the conducting farms, natural-social situation. Mongolian poetry has a glimpse of the structure of the universe in the context of nomadic civilization in the context of extreme climatic conditions. Mongolian verse is created based on the general structure of the universe which is linked to the nomadic culture developing under the four season with extreme climates. The structure of the strophe of Mongolian verse is usually being created by couplet and quatrain or tercet and sixian. Also, Mongolian people regard that the live is developing in wisdom. Therefore, the couplet of Mongolian verse which is the main part is created by wisdom. So, the number of orthotone and atonic words are balanced to the syllable in Mongolian verse. This couplet is being parallel and irrespective of each other because the couplet verse is symmetry. But the meaning of the verse is going deeply from the first line to next. In the course of historical development of strophe of Mongolian verse is developed and extended from couplet to quatrain. Therefore, the structure of quatrain is very similar to couplet.

Номзүй

- Аристотель. 1969. *Туурвил зүй*. Орч. Ш.Гаадамба. Уб.
- Байгалсайхан С. 1995. *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Уб.
- Буяннэмэх С. 1935. *Уран зохиолын үүд*. Гар бичмэл эх. Улсын нийтийн номын сан.
- Гаадамба Ш., Сампилдэндэв Х. 1988. *Монгол ардын аман зохиол*. Уб.
- Гаадамба Ш. 1989. *Утга зохиолын онолын үндэс*. Уб.
- Гаадан Х. 1986. *Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл*. Уб.
- Галбаатар Д. 2012. *УРАН ЗОХИОЛ: Онол, Түүх, Шүүмж*. НЭВТЭРХИЙ ТОЛЬ. Уб.
- Галбаяр Г. 2002. *Уран зохиол шинжлэлийн лекц*. Уб.
- Гаспаров М. Л. 1974. *Современный русский стих*. (метрика и ритмика) М.
- Герасимович Л. К. 1975. *Монгольское стихосложение*. Л.
- Дамдинсүрэн Ц. 1957. *Олег цэцэний орчуулгын тайлбар*. Монгол хэл бичгийн тухай. Уб.
- Дамдинсүрэн Ц. 1959. *Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив*. Уб.
- Жамба Д. 1958. *Монгол шүлгийн хэлний тухай өгүүлэл*. Монгол түүх, хэл бичиг сэтгүүл. №3.
- Жамбалсүрэн Н. 1956. *Монгол шүлэг*. Утга зохиол сонин. №8.
- Жирмунский В. 1975. *Теория стиха*. Л.
- Kathleen Morner, Ralph Rausch. 1998. *Dictionary of Literary Terms*. McGraw Hill.
- Macdonell A. Arthur. 1893. *Sanskrit-English dictionary*. London.
- Монголын уран зохиолын дээжис*. 108 боть. 2005. Сайн үгсийн сан-III. 6-р боть. Уб.

- Нацагдорж Д.** 2006. *БҮРЭН ЗОХИОЛ*. Тэргүүн дэвтэр. Оршил, удиртгал бичиж, тайлбар, ном зүй үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв. Уб.,
- Отгонсүрэн Д.** 1984. *Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга, уран сайхны онцлог*. Уб.,
- Түдэв Л.** 2002. *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган VI. Уб.,
- Rachewiltz Igor De.** 1972. *The Secret History of the Mongols*. Published by Indiana University. Bloomington.,
- Ринчен Б.** 1970. *Монгол шүлгийн учир*. Хэл зохиол судлал. Том-VII-VIII. Уб.
- Содном Б.** 2008-2009. *Монгол шүлгийн арга маяг*. Зохиолсудлал. Уб.,
- Qad-un ündüsün quriyangui altan tobči.* 2002. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Шаравын Чоймаа. Уб.
- Хамгашалов А.** 1940. *Опыт исследования бурят-монгольского стихосложения*. Улан-Удэ.,
- Хүрэлбаатар Л.** 1989. *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*. Уб.
- Kesigtoytaqu Ї.** 1999. *Mongyol-un erten-ü udq-a jokiyal-un sin-e sudulul. Öbörmongyol-un arad-un keblel-ün qoriy-a.*,
- Цэдэв Д.** 1974. *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб.
- Цэнд Д.** 1972. *Монголын орчин үеийн уянгын яруу найраг*. Уб.
- Цэнд Д.** 1979. *Монгол шүлгийн тогтолцооны асуудалд*. Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд. Уб.,
- Цэрэнсодном Д.** 1977. *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*. Уб.
- Цэрэнсодном Д.** 2012. *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Уб.
- Чимид Ч.** 1968. *Монгол шүлгийн тогтолцоо*. “Үгийн ил шид” эмхэтгэл. Уб.
- Энхбаяр С.** 2000. *Утга зохиолын онол-туурвил зүй*. Уб.,
- Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyaysan altan tobči kemekü orusibai.* Orusil bičigsen Ša. Bira., 1990. Ulaγanbayatur.,
- Явуухулан Б.** 1985. *Түүвэр зохиол*. Эмх. Ж.Адъяа, Я.Баатар. Уб.
- <http://news.gogo.mn/r/91613>
- <https://prezi.com/p4rgpohjrztq/presentation/>